

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2024 оны 11 сарын 07 өдөр

№ R-2024-51

Улаанбаатар хот

Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр батлах тухай

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.11 болон 36.12 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь заалт, Монголбанкны Ерөнхийлөгч болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А-262/262 тоот хамтарсан тушаалаар батлагдсан Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журмын 1 дүгээр зүйлийн 1.2.6 дахь заалт, 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэг, ХасБанк ХК (“Банк”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.26 дахь хэсэгт тус тус заасны дагуу Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн ээлжит хурлаараа дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн R-2024-40 тоот тогтоолоор батлагдсан Банкны хувьцаа эргүүлэн худалдан авах анхны хөтөлбөр дуусгавар болохтой холбогдуулан, Банкны хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 3 сарын хугацаанд үргэлжлэх хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг батлахыг ТУЗ-д санал болгосныг; мөн
- ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын саналыг хэлэлцээд хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг батлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр (“Хөтөлбөр”)-ийг Банк өөрийн гаргасан энгийн хувьцааны 2,200,000 ширхэг хүртэлх хувьцааг эргүүлэн худалдан авах эрхтэйгээр, дараах нөхцөлөөр баталсугай:

1	Эргүүлэн худалдан авах хувьцааны тоо	2,200,000 ширхэг хүртэл
2	Эргүүлэн худалдан авах хувьцааны үнэ	826.00 төгрөг хүртэл
3	Хөтөлбөрт зарцуулах нийт дүн	1,750,000,000.00 төгрөг хүртэл
4	Хөтөлбөр хэрэгжих хугацаа	3 сар

- Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа нь Монголбанкны зөвшөөрөл олгож, нийтэд зарласан өдөр эсхүл хувьцаа эргүүлэн худалдан авах анхны хөтөлбөр дуусгавар болсон өдрийн аль сүүлийн өдрөөс эхлэн 3 сар үргэлжлэх ба нийт эргүүлэн худалдан авах хувьцааг бүхэлд нь худалдан авсан, эсхүл Хөтөлбөрт зарцуулах нийт дүнг бүрэн зарцуулснаар уг хугацаанаас өмнө дуусгавар болж болно.

- Хөтөлбөрийн дагуу эргүүлэн худалдан авсан хувьцааг халаасласугай.

4. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хувьцаа эргүүлэн худалдан авах ажлыг гүйцэтгэх, зохицуулагч байгууллагаас зохих зөвшөөрөл авах, харилцах зэрэг энэ ажлыг зохион байгуулахтай холбоотой шаардлагатай, эсхүл зохистой гэж үзсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд даалгаж, холбогдох эрхийг олгосугай.
5. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

A black ink handwritten signature.

Н.МӨНХЦЭЛМЭГ